БАТЛАВ
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА, БРИГАДЫН
ГЕНЕРАЛ Ц.АМГАЛАНБАЯР

# АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
/2019-2020 ОН/

2019.02.25 Улаанбаатар хот

| Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа | № | Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтан |
|---|---|---|---|---|---|
| Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр: | | | | | |
| 4.1.1.1. төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх | 1 | 1.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дэргэдэх “Төрийн албаны салбар зөвлөл”-ийн ажлыг тогтмолжуулах; | 2019 оны 7, 12 дугаар сард | -Төрийн албаны зөвлөлийн бодлогыг хэрэгжүүлж ажлын уялдаа холбоо сайжирна. | Захиргааны удирдлагын газар |
| 4.1.1.2. нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтны мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх; | 2 | 2.1. Алба хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч, алба хаагчдын шилжилт хөдөлгөөн, шагнаж урамшуулах, хариуцлага тооцох ажлыг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулах; | 2019 он | Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана | Захиргааны удирдлагын газар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4.1.1.7. нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх | 3 | 3.1 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих анги, салбар нэгжүүдийн цахим хуудаст нийтийн албан тушаалтанд холбогдох гомдол, мэдээллийг хүлээн авах нөхцлийг бүрдүүлж, хариуцлага тооцох, хяналт тавих боломжийг нэмэгдүүлэх; | 2019 он | Гомдол, мэдээлэл хүлээн авах боломж бүрдсэн байна. | Мэдээлэл технологийн хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар хэлтэс, хорих анги салбар нэгж |
| | | 3.2 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих анги салбар нэгжийн Ёс зүйн хорооны тайланг хагас, бүтэн жилээр нэгтгэж, дүнг ШШГЕГ-ын Ёс зүйн хороогоор хэлэлцэн салбар нэгжийн ёс зүйн хорооны үйл ажиллагааны үр дүнг чанаржуулах; | 2019 он | Салбар нэгжийн Ёс зүйн хорооны үйл ажиллагааны үр дүн дээшилсэн байна. | Захиргааны удирдлагын газар |
| 4.1.1.9. төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох боломжийг сайжруулах | 4 | 4.1 ШШГБ-ын үйл ажиллагаанд төрийн мэдээллийн нэгдсэн ХУР+ДАН системийг нэвтрүүлж бусад төрийн байгууллагуудаас авч байгаа мэдээллийн нууцлал аюулгүй байдлыг хангасан сүлжээнд шилжүүлэх; | | Байгууллагын үйл ажиллагаа сайжирсан байна. | Захиргааны удирдлагын газар |
| | | 4.2 Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд ашиглагдаж байгаа мэдээллийн сан болон гэмт хэрэгт холбогдсон этгээдийн зөрчлийн хэргийн болон жолоодох эрхийн мэдээллийн санг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага Цагдаагийн | 2019-2022 | Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн байна. | Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | байгууллага харилцан солилцох талаар эрх зүйн орчинг бүрдүүлэх, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | | | |
| 4.1.1.10. нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх | 5 | 5.1 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад 2018-2019 онд зохион байгуулах албаны болон давтан сургалтыг хөтөлбөрийг баталж, хэрэгжилтийг хангах ажиллах; | 2019 он | Батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний хүрээнд хичээл сургалтыг тогтмол, чанартай зохион байгуулж, алба хаагчдыг бүрэн хамруулсан байна. | Захиргааны удирдлагын газар |
| | | 5.2 Сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж мэргэшүүлэх сургалтад алба хаагчдыг хамруулах; | 2019 он | Алба хаагчдын мэдлэг, ур чадвар дээшилсэн байна. | Захиргааны удирдлагын газар |
| | | 5.3 Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн актуудаар богино хугацааны болон давтан сургалтад албан хаагчдыг хамруулах; | 2019 он | ШШГЕГ болон хотын бүсийн хорих анги, салбар нэгжийн нийтийн албан тушаалтны 90 хувийг хамруулсан байна. | Хяналт шалгалтын газар |
| Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр: | | | | | |
| 4.1.2.1. төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх | 6 | 6.1 Хүний нөөцийн цахим програмыг бүрэн ашиглаж, баяжилтыг тухай бүр хийх, ШШГБ-ын алба хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх, | 2019 он | Хүний нөөцийн хөдөлгөөний бүртгэл, мэдээлэл цахим хэлбэрт бүрэн орсон байна. | Захиргааны удирдлагын газар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | шаардлагатай мэдээлэл, лавлагаагаар хангаж ажиллах | | | |
| | | 6.2 Шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй талаарх иргэн, хуулийн этгээдэд олгосон лавлагааг шалгах програм хангамжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх; | 2019 он | Лавлагаа олгох програм хангамжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэнээр бүртгэлийн дугаар, лавлагаа хүсэгчийн регистр, маягтын дугаарыг цахим хуудсанд байршуулсан хаягт илгээснээр лавлагааны үнэн зөв эсэхийг харуулна. | Шийдвэр гүйцэтгэх алба |
| | | 6.3 Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудад ажиллагааны мэдээллийг онлайн хэлбэрээр өгч, мэдээллийг нээлттэй болгох; | 2019 он | Төрийн үйлчилгээ түргэн шуурхай хүргэгдсэн байна. | Шийдвэр гүйцэтгэх алба |
| 4.1.2.4. эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох | 7 | 7.1 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих анги салбар нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх зорилгоор дотоод хяналт шалгалт явуулах эрх бүхий албан тушаалтныг ШШГЕГ-ын даргын тушаалаар томилуулж, тэднийг мэргэшүүлэх сургалтад хамруулсан байх; | 2019 он | Эрх бүхий албан тушаалтан үйл ажиллагаа сайжирч, үр дүн дээшилсэн байна. | Хяналт шалгалтын газар |
| | | 7.2 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих анги салбар нэгжид зайлшгүй хийгдэх дотоод хяналт шалгалтын талаар чиглэл өгч, биелэлтийг хангуулж, урьдчилан сэргийлэх; | 2019 он | Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор салбар нэгжид зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. | Хяналт шалгалтын газар |
| | | 7.3 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын | 2019 он | Шинэчлэн батлагдсан хууль, журамд нийцсэн байна. | Хяналт шалгалтын газар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | “Хяналт шалгалт хийх журам”-ыг шинэчлэн батлуулж, мөрдөж ажиллах; | | | |
| 4.1.2.5. төрийн үйлчилгээний шударга ил тод, нээлттэй байдлын талаарх судалгааг тогтмол хийж, үр дүнг үйл ажиллагаандаа ашиглах | 8 | 8.1 Хөндлөнгийн судалгааны байгууллагаар 2018 онд хийлгэсэн хэрэглэгчийн үнэлгээний тайланд тусгагдсан зөвлөмжийн дагуу чиглэл хүргүүлж, үр дүнг үйл ажиллагаандаа ашиглах; | 2019 он | Хэрэглэгчийн үнэлгээний санал, зөвлөмжийг хэрэгжүүлж, үр дүнг дээшлүүлсэн байна. | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс |
| | | 8.2 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэдэд түргэн шуурхай үйлчлэх, иргэд олон нийтийн мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах; | 2019 он | Үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдал хангагдсан байх;<br>-Иргэд, байгууллагад үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна. | Захиргааны удирдлагын газар |
| | | 8.3 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад биеэр хандаж ирсэн иргэнийг угтах “Нэг цонхны үйлчилгээ”-ний мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлж, иргэний санал хүсэлтийг хүлээн авч, дүнг үйл ажиллагаандаа тусгах; | 2019 он | Төрийн үйлчилгээ олон нийтэд түргэн, шуурхай хүрсэн байна. | Захиргааны удирлагын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих анги салбар нэгж |
| 4.1.2.6. өргөдөл, гомдол, мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл, гомдол мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх | 9 | 9.1 Цахим хэлбэрээр гаргасан өргөдөл, гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг иргэд, олон нийтэд мэдээллэх; | 2019 он | Цахим хэлбэрээр гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэгдсэн байна. | Захиргааны удирдлагын газар |
| | | 9.2 Иргэний өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах албан тушаалтны нэр, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авах цагийн хуваарийг тухай бүр | 2019 он | Мэдээлэл цахим хуудаст нийтлэгдэж, иргэд, олон нийт мэдээллээр хангагдсан байна. | Захиргааны удирдлагын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих анги салбар нэгж |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | цахим хуудас, мэдээллийн самбарт тодорхой байршуулах; | | | |
| Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр: | | | | | |
| 4.1.3.1. Улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх, төсвийн хөрөнгө, гадаад зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх | 10 | 10.1 Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж холбогдох мэдээллийг батлагдсан журмын дагуу цахим хуудсандаа байршуулах; | 2019 он | Мэдээлэл ил тод нээлттэй байна | Санхүү, үйлдвэр, хөрөнгө, оруулалтын газар |
| | | 10.2 Гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх, хөтөлбөрийн хэрэгжилт, судалгааг гаргаж цахим хуудсанд мэдээлэх; | 2019 он | | |
| | | 10.3 Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд мэдэгдэл, тайлбар гаргуулах, тэдгээрийг бүртгэх, тайлан мэдээ гаргах; | 2019 он | Мэдэгдэл, тайлбар гаргаж хэвшсэн байна. | |
| 4.1.3.2. Төсвийн төлөвлөлтийн үр ашигтай байдал, гүйцэтгэл, зарцуулалтын хөндлөнгийн хяналт, хариуцлагыг дээшлүүлэх | 11 | 11.1 ШШГБайгууллагын хэмжээнд улсын төсөв болон дотоод эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэж буй бүтээн байгуулалтын ажилд хяналт тавих; | 2019 он | Нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг байгууллагын хэмжээнд мөрдөж ажилласан байна | Санхүү, үйлдвэр, хөрөнгө, оруулалтын газар |
| | | 11.2 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тайлагналтад хяналт тавих; | 2019 он | | |
| Дөрөв. Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4.1.4.2. тендер шалгаруулалтын талаар гарсан гомдлыг хянан шийдвэрлэх журмыг шинэчлэх, гаргасан шийдвэр, дүгнэлтийг олон нийтэд ил тод болгох | 12 | 12.1 Худалдан авах үйл ажиллагааг цахимжуулж, зарлагдсан тендерийг сайтад тогтмол байршуулан "Шилэн тендер"-ийн тогтолцоонд шилжүүлэх ажлыг хэрэгжүүлэх; | 2019 он | Худалдан авах ажиллагааны ил тод байдал хангагдана | Санхүү, үйлдвэр, хөрөнгө, оруулалтын газар |
| 4.1.4.3. Худалдан авах ажиллагааны бодлого төлөвлөлтийг сайжруулж, ил тод болгох, олон нийтээр хэлэлцүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх | 13 | 13.1 Тухайн онд батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарласан байх; | Тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш тендер зарлах хүртэлх хугацаанд | Худалдан авах ажиллагааны нээлттэй байдлыг хангана | Санхүү, үйлдвэр, хөрөнгө, оруулалтын газар |
| Арав. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр: | | | | | |
| 4.1.10.1. авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх | 14 | 14.1 Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, олон нийтэд сурталчлах; | 2019 он | Иргэд, олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна. | Хяналт шалгалтын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих анги салбар нэгж |
| 4.1.10.4. авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах | 15 | 15.1 Авлигатай тэмцэх газраас сургагч багш бэлтгэх сургалтад холбогдох албан тушаалтныг бүрэн хамруулах; | 2019 он | Сургагч багш бэлтгэгдсэн байна. | Хяналт шалгалтын газар |

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4.1.4.2. тендер шалгаруулалтын талаар гарсан гомдлыг хянан шийдвэрлэх журмыг шинэчлэх, гаргасан шийдвэр, дүгнэлтийг олон нийтэд ил тод болгох | 12 | 12.1 Худалдан авах үйл ажиллагааг цахимжуулж, зарлагдсан тендерийг сайтад тогтмол байршуулан "Шилэн тендер"-ийн тогтолцоонд шилжүүлэх ажлыг хэрэгжүүлэх | 2019 он | Худалдан авах ажиллагааны ил тод байдал хангагдана | Санхүү, үйлдвэр, хөрөнгө, оруулалтын газар |
| 4.1.4.3. Худалдан авах ажиллагааны бодлого төлөвлөлтийг сайжруулж, ил тод болгох, олон нийтээр хэлэлцүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх | 13 | 13.1 Тухайн онд батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарласан байх | Тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш тендер зарлах хүртэлх хугацаанд | Худалдан авах ажиллагааны нээлттэй байдлыг хангана | Санхүү, үйлдвэр, хөрөнгө, оруулалтын газар |
| Арав. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр: | | | | | |
| 4.1.10.1. авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх | 14 | 14.1 Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, олон нийтэд сурталчлах | 2019 он | Иргэд, олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна. | Хяналт шалгалтын газар,<br>Аймаг, нийслэл дэх ШШГГ, хэлтэс, хорих анги салбар нэгж |
| 4.1.10.4. авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах | 15 | 15.1 Авлигатай тэмцэх газраас сургагч багш бэлтгэх сургалтад холбогдох албан тушаалтныг бүрэн хамруулах | 2019 он | Сургагч багш бэлтгэгдсэн байна. | Хяналт шалгалтын газар |

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР